



Б Н М А У

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1991 оны 12 сарын 25

№ 365

Улаанбаатар
хот

Улсын үйлдвэрийн газар байгуу-
лах тухай

Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас
ТОГТООХ нь:

1. БНМАУ-ын Аж ахуйн нэгжийн хуулийн 10 дүгээр зүйлийг
үндэслэн Хүнс хоолны технологи хяналтын лабораторийг Улсын
үйлдвэрийн газраар ажиллуулсугай.

2. Хүнс, хоолны технологи хяналтын лабораторийн пүрмийг
хавсралт ёсоор баталж, пүрмийн санг 374,6 мянган төгрөгөөр
тогтоосугай.

3. Энэ тогтоом гарсантай хөбөглүүлэн "Хүнс хоолны тех-
нологи хяналтын лаборатори шинэчлэн байгуулах тухай" Улаан-
баатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны 1991 оны 136
дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай. ✓



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-
ГААНЫ ДАРГА

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА

Л.ЭНЭВТИ

Ц.БОЛДСАЙХАН

Гүйцэтгэх
Зөвлөл
Төрийн захиргаа

Улаанбаатар хотын АХ-ын гүйцэтгэх
захиргааны 1991 оны 365 тоот
тогтоолын зөвлөлт.

ХҮНС, ХООЛНЫ ТЕХНОЛОГИ ХЯНАЛТЫН ЛАБОРАТОРИЙН ДҮРЭМ /УУГ/

Нэг. Нийтлэг үндэслэл.

1. Хүнс, хоолны технологи хяналтын лаборатори нь Схтэбрийн дүүргийн ОСГ-ны дугаар хорооны нутаг дэвсгэрт г гудамжны тоот байшинд ажил үйлчилгээ явуулна.

2. Лаборатори нь дараах ажил эрхлэнэ. Үүнд:

а/өмчийн бүх төрөлд хамаарагдах байгууллага, иргэдийн эрхлэж байгаа худалдаа, нийтийн хоолны газруудын хүнсний зориулалттай бараа, хоол, ундааны нийрлэглэл, бүтэц чанарт шинжилгээ хийх.

б/Монгол улсын хоол, ундааны жор, технологийг боловсруулж болгох, үйлдвэрлэлд нэвтрүүлэх.

в/Хүнсний бүтээгдэхүүн, хоол, ундааны зүйлийг туршилтын журмаар үйлдвэрлэж худалдаална.

3. Лаборатори нь БНМАУ-ын хууль тогтоомж, хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд материал шалгах, улсын стандарт, техникийн нөхцөлийг удирдлага болгоно.

4. Лаборатори нь хотын АХ-ын гүйцэтгэх захиргааны харъяанд аж ахуйн тооцоон дээр ажиллана.

5. Лаборатори нь тусгай тамга, тэмдэг, торгуулийн болон бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, банкны тооцооны харилцах данстай байна.

Хоёр. Лабораторийн үүрэг, хариуцлага.

1. Худалдаа, нийтийн хоолны байгууллага, иргэдээс хөдөлмөрийн хэрэгцээнд нийлүүлэхээр бэлтгэсэн хүнсний бүтээгдэхүүн, бэлэн хоол, ундаанаас өөрийн сансачлагаар буюу бусдын захиалгаар хяналтын шинжилгээний дээж авч шинжлэн дүгнэлт гаргаж байх.

2. Хүнсний хэрэгцээнд тохирохгүй бүтээгдэхүүн, хоол, ундаа үйлдвэрлэж худалдаалсан байгууллага, иргэдийн худалдаа үйлчилгээг зогсоох талаар яаралтай арга хэмжээ авах.

3. Худалдаа, нийтийн хоол, бэлтгэн нийлүүлэгч байгууллага, хувь хүмүүсийн хооронд бүтээгдэхүүний чанар, бүтэц, нийрлэглэл талаар гарсан маргааныг байгууллага хүмүүсийн нэхэмжлэлийн дагуу шийдвэрлэж байх.

2.

4. Монгол үндэсний хоол, ундааны шинэ нэр төрлийг бий болгох зор, технологийг сууцлаж тогтоох талаар шинжилгээ, сорил туршилтын ажил гүйцэтгэх.

5. Шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн, хоолны талаар мэдээлэл гаргаж зөвлөлтөө, зөвлөмж боловсруулан үйлдвэрлэлд нэвтрүүлэх.

6. Шинэ нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн, хоолны стандарт, техникийн нөхцөл боловсруулах, патент эрхийн гэрчилгээ олгох, санал дүгнэлт гаргахад оролцох.

7. Орон нутгийн байгалийн баялаг, өгөөж ашиглан хүнсний бүтээгдэхүүн, хоолны амт, үнэр, өнгө үзэмжийг цэвэрлүүлэх туршилт сорилтын ажлыг гүйцэтгэнэ.

8. Хүнсний бүтээгдэхүүн, хоолны талаар хийсэн шинжилгээ дүгнэлт нь суруу гэж нотлогдсон тохиолдол гарсан хохиролыг хариуцана.

9. Туршилт шинжилгээг бүрэн чанартай, хугацаанд нь гүйцэтгэх хүрэгтэй.

Турав. Лабораторийн эрх.

1. Өмчийн бүх төрөлд хамрагдах байгууллага, иргэдийн үйлдвэрлэж байгаа хүнсний бүтээгдэхүүн, хоолны чанар байцлыг шалгах зорилгоор дээж авч лабораторийн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах.

2. Чанар муудсан, стандарт, технологийн нөхцлийн шаардлага хангахгүй хоол, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж, худалдаалсан, бэлтгэн нийлүүлсэний улмаас хөдөлмөрчдийн эрүүл мэнд, эрх ашиг хохироосон үйл ажиллагааг зогсоох, хууль хяналтын байгууллагад мэдээлэх.

3. Тогтоосон хугацаанд шинжилгээнд дээж, сорьцоо өгөөгүй байгууллага, хүмүүст шаардах, хяналтын шинжилгээний үнэ хөлсийг тухайн байгууллага, иргэдээс шууд нэхэмжлэн авах эрхтэй болно.

Дөрөв. Удирдлага, зохион байгуулалт.

1. Лабораторийн удирдах дээд байгууллага нь хотын АХ-ын гүйцэтгэх захиргаа мөн.

2. Хотын АХ-ын гүйцэтгэх захиргаа лабораторийн захирлыг томилж байна.

3. Лабораторийн захирал үйлдвэрлэл, туршилт шинжилгээний ажлыг шууд удирдана.

4. Аливаа асуудлыг лабораторийн бүх ажилчдын хурлаар хэлэлцэж, олонхийн саналаар шийдвэрлэж байна.

5. Лабораторийн захирал байгууллага төлөөлж гэрээ хэлцэл хийх эрхтэй.